

**2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН  
УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

№	Товч агуулга	Хариуцах албан тушаалтан
1	Нийслэлийн 2018 оны төсөв батлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний задаргааг 2017 оны 12 дугаар сарын 18-ны дотор НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс ирүүлэх. /Захирагчийн ажлын алба, Хэрэгжүүлэгч агентлагууд, Дүүргүүд/	2018 онд хэрэгжүүлэх ямар нэгэн төсөл арга хэмжээ байхгүй болно.
2	Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудынхаа нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж 2017 оны 12 дугаар сарын 18-ны дотор НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс ирүүлэх. Жич: /Төлөвлөлт хийхдээ тоонд бус чанарт үндэслэн төлөвлөж, хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, хүр үр дүнг бодитой, нарийвчилж төлөвлөх, 2018 оны батлагдсан төсвийн хүрээнд/ /Захирагчийн ажлын алба, Хэрэгжүүлэгч агентлагууд, нийслэлийн төсөвт болон өмчит байгууллагууд/	Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудынхаа нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж НЗДТГ-ын БТХ-т хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлэв.
3	Баярын өдрүүдэд мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд хэрэглээний халуун, хүйтэн болон ундны ус, дулаан, цахилгаанаар тасалдалгүй хэвийн хангах, шуурхай бригадыг бэлэн байлгах, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, цагийн хуваарь зэрэгт Захирагчийн ажлын алба хяналт тавих. /Нутгийн захиргааны нийт байгууллагууд/	Баярын өдрүүдэд байгууллагын албан хаагчид жижүүр ээлжийн хийж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллав.
4	2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 18.00 цагаас гүйлгээ хаагдах тул байгууллагын удирдлага, санхүү бүртгэлийн ажилтнууд гүйлгээ хаагдахаас өмнө төлбөр тооцоогоо хийж, өр авлагагүй гарах тал дээр анхаарч ажиллах. /Нийт байгууллагууд/	Манай байгууллага 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 18.00 цагаас өмнө төлбөр тооцоогоо бүрэн хийж дууссан. Ямар нэгэн өр төлбөрийн үлдэгдэлгүй болно.